



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 367

Улаанбаатар хот

Г “Молор орд ББСБ” ХХК-ийн Г
банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Молор орд ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд холбогдох тэмдэглэгээг 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор хийлгэхийг “Молор орд ББСБ” ХХК /Б.Хонгорзул/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН